

## АГУУЛГА

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ .....	2
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн: .....	2
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ: .....	5
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	6
2.1. Нэгдсэн төсвийн орлого .....	7
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага .....	10
2.3. Төсвийн тэнцэл .....	11
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА .....	11
3.1. Гадаад худалдааны эргэлт: .....	11
3.2. Экспорт .....	13
3.3. Импорт .....	15
ДӨРӨВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	16
4.1. Мөнгөний нийлүүлэлт .....	16
4.2. Гадаад валютын албан нөөц .....	19
4.3. Төлбөрийн тэнцэл .....	20
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	21
5.1. Хүн ам, ажил эрхлэлт .....	21
5.2. Ажилгүйдэл .....	21
ДҮГНЭЛТ .....	21

## НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

### 1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:

**Эцсийн ашиглалтын аргаар: 2019 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр оны үнээрх Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 27.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.9 их наяд төгрөг буюу 16.5 хувиар өссөн байна.**




Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн<sup>1</sup> нь 2015 оны мөн үед 17.2 их наяд, 2016 оны мөн үед 17.1 их наяд, 2017 оны мөн үед 20.0 их наяд, 2018 оны мөн үед 23.3 их наяд төгрөгт хүрсэн бол 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 27.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.9 их наяд төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Нэрлэсэн ДНБ-ий өсөлтөд хөрөнгийн хуримтлал өмнөх оны мөн үеэс 1.4 их наяд төгрөг буюу

14.4 хувиар, эцсийн хэрэглээ мөн 1.6 их наяд төгрөг буюу 11.1 хувиар, цэвэр экспорт 0.9 их наяд төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

### Эцсийн ашиглалтын аргаар: 2019 оны оны 3 дугаар улирлын байдлаар



**2010 оны зэрэгцүүлэх үнээр ДНБ 13.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.8 их наяд төгрөгөөр нэмэгдэж, ДНБ-ий бодит өсөлт 6.1 хувьтай гарсан байна.**

Зэрэгцүүлсэн үнээр тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн<sup>2</sup> нь 2015 онд 11.6 их наяд, 2016 онд 11.4 их наяд, 2017 онд 12.0 их наяд, 2018 оны мөн хугацаанд 12.7 их наяд төгрөг байсан бол 2019 оны

<sup>1</sup> - эцсийн ашиглалтын аргаар оны үнээр тооцоход

<sup>2</sup> - эцсийн ашиглалтын аргаар 2010 оны зэрэгцүүлсэн үнээр тооцоолоход

3 дугаар улирлын байдлаар 13.5 их наяд төгрөгт хүрч ДНБ-ийн бодит өсөлт 6.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


ДНБ-ий бодит өсөлтөд хөрөнгийн хуримтлал 1.2 их наяд төгрөг буюу 24.5 хувиар, эцсийн хэрэглээ 0.7 их наяд төгрөг буюу 7.7 хувиар өссөн нь нөлөөлж, харин цэвэр экспорт 1.1 их наяд төгрөгөөр буурчээ.

2019 оны 3 дугаар улирлын байдлаар ДНБ-ий 73.4 хувийг эцсийн хэрэглээ, 45.5 хувийг хөрөнгийн хуримтлал эзэлж байна.

**Эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр тооцсон ДНБ 3.9 их наяд төгрөгөөр нэмэгдэж, үүний дотор эцсийн хэрэглээ 1.6 их наяд төгрөг, хөрөнгийн нийт хуримтлал 1.4 их наяд төгрөг, цэвэр экспортын ашиг 0.9 их наяд төгрөгөөр өссөн байна.**

ДНБ-ийг улирлаар харуулбал жил бүрийн эхний улиралд ДНБ-ий хэмжээ харьцангуй бага байснаа хоёрдугаар улирлаас хойш өсдөг зүй тогтол ажиглагдаж байна. 2019 оны 3 дугаар улиралд ДНБ-ий хэмжээ 27.2 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 3.9 их наяд төгрөгөөр өсч, сүүлийн 4 жилийн өндөр үзүүлэлт гарлаа.

**График 3. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2019 оны 3 дугаар улиралд цэвэр экспорт 17.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.9 их наяд төгрөгөөр өссөн байна.

**Үйлдвэрлэлийн аргаар: 2019 оны 3 дугаар улирлын байдлаар оны үнээр тооцсон ДНБ 9.7 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд аж үйлдвэр 0.6 их наяд, үйлчилгээ 0.5 их наяд, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.2 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.**


**График 4. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2015-2018 оны 3 дугаар улиралд аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний хэмжээ 2.0-3.1 их наяд төгрөг байснаа 2019 оны 3 дугаар улиралд 3.7 их наяд төгрөг, мөн хугацаанд үйлчилгээний салбарын хэмжээ 2.8-3.3 их наяд төгрөг байснаа 2019 оны 3 дугаар улиралд 3.8 их наяд төгрөг болж тус тус өссөн байна. Үйлчилгээний салбарт болон бүтээгдэхүүний цэвэр татварт өсөлт гарсан нь ДНБ-ий хэмжээ нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

**2019 оны 3 дугаар улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий 40.5 хувийг үйлчилгээ, 36.3 хувийг аж үйлдвэр, 11.9 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар, үлдсэн 11.4 хувийг хөдөө аж ахуй эзэлсэн байна.**




2019 оны 3 дугаар улиралд үйлдвэрлэлийн аргаар, оны үнээрх ДНБ-ийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 17.1 хувиар, үйлчилгээний салбарын үйлдвэрлэл 17.0 хувиар, аж үйлдвэрийн салбар 15.6 хувиар, хөдөө аж ахуйн салбар 6.1 хувиар тус тус өссөн байна.

2019 оны 3 дугаар улиралд 2010 оны зэрэгцүүлсэн үнээрх ДНБ 5.0 их наяд төгрөгт хүрч, бодит ДНБ-ий 42.1 хувийг үйлчилгээ, 31.5 хувийг аж үйлдвэр, 14.3 хувийг хөдөө аж ахуй, 12.1 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар эзэлж байна.

## 1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:

2018 онд ДНБ-ий бодит өсөлт 6.9 хувьд хүрч, өмнөх оноос 1.8 пунктээр өссөний үр дүнд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 9,929.3 мянган төгрөг болж өмнөх оноос 13.1 хувь буюу 1,151.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

График 6. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ба эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2011 онд ДНБ-ий бодит өсөлт 17.3 хувь байх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,685.4 мянган төгрөг байсан. ДНБ-ий бодит өсөлт 2011 оноос хойш тасралтгүй буурч, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2014-2016 онуудад нэмээгдээгүй байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн өсөлт 2014 оны 3 дугаар улиралд 9.1 хувьд хүрч өссөн ба 2016 оны 3 дугаар улиралд -1.4 хувь хүртэл буурсан. Харин 2016 оны 3 дугаар улирлаас эхлэн эдийн засаг сэргэж, эдийн засгийн бодит өсөлт тогтвортой нэмэгдэж, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 6.3 хувьд хүрсэн байна. Үүнд гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ өссөнөөр экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн, улсын төсвийн болон хувийн хэвшлийн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа зэрэг нь нөлөөлжээ.

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

**2019 оны 3 дугаар улирлын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 7,749.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 7,264.4 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 484.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.**

2019 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 434.2 тэрбум төгрөг буюу 5.9 хувиар давж биелсэн бол төсвийн нийт зарлага 1,337.3 тэрбум төгрөг буюу 15.5 хувиар төлөвлөснөөс бага зарцуулагдсан байна.

### Монгол Улсын нэгдсэн төсөв

Хүснэгт 1.

/тэрбум.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт (+/-)	
	1	2	(3-2)	(3-2)/2
	2019.09		Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн	7,314.8	7,749.0	434.2	5.9
Нийт зарлагын дүн	8,601.7	7,264.4	-1,337.3	-15.5
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1,286.9	484.6	1,771.6	-137.7
<b>Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь</b>	-9.4	3.5		

Эх сурвалж: Сангийн яам

2019 оны 3 дугаар улиралд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 7,749.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 1,232.4 тэрбум төгрөг буюу 18.9 хувиар нэмэгдэж, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 7,264.4 тэрбум төгрөгт хүрч 989.4 тэрбум төгрөг буюу 15.8 хувиар өссөн байна.

### Нэгдсэн төсвийн өөрчлөлт, 2015-2018

Хүснэгт 2.

/тэрбум.төг/

Үзүүлэлт	Жилийн эцсийн байдлаар				Өөрчлөлт(+/-)	
	2016	2017	2018	2019	дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	4,012.7	5,035.1	6,516.6	9,234.9	2,718.3	41.7
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	6,064.4	5,773.0	6,275.0	9,222.9	2,947.9	47.0
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-2,051.7	-737.9	241.7	484.6	242.9	100.5
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-18.0	-6.1	1.9	3.5		

Эх сурвалж: Сангийн яам

2019 оны 3 дугаар улирлын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 484.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 242.9 тэрбум төгрөг буюу 100.5 хувиар сайжирсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ашгийн ДНБ-д эзлэх хувь 3.5 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 1.6 пунктээр сайжирсан байна.

## 2.1. Нэгдсэн төсвийн орлого

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 7,749.0 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 18.9 хувь буюу 1,232.4 тэрбум төгрөгөөр өсч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 5.9 хувь буюу 434.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 90.5 хувийг татварын орлого, 9.5 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Улсын төсөв 3.5 хувь буюу 192.6 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн төсөв 8.5 хувь буюу 138.5 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 11.2 хувь буюу 34.1 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн бол Орон нутгийн төсөв 2.0 хувь буюу 43.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 18.3 хувь буюу 876.5 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 6.6 хувь буюу 129.2 тэрбум төгрөгөөр нийгмийн даатгалын сангийн орлого 18.4 хувь буюу 273.4 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 13.2 хувь буюу 39.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

### Нэгдсэн төсвийн орлогын 2019 оны эхний 9 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Хүснэгт 3.

/тэрбум төгрөг/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,486.8	6,563.9	2,123.2	2,079.8	1,623.0	1,761.5	304.7	338.8
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	161.2	69.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	862.0	838.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,463.6	5,656.3	2,123.2	2,079.8	1,623.0	1,761.5	304.7	338.8
<b>Татварын орлого</b>	<b>4,397.8</b>	<b>4,714.2</b>	<b>898.9</b>	<b>882.4</b>	<b>1,168.9</b>	<b>1,307.4</b>	<b>304.7</b>	<b>338.8</b>
Орлогын албан татвар	1,017.8	1,181.1	620.8	604.3	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	1,168.9	1,307.4	304.7	338.8
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	117.7	115.9	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,655.6	1,765.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	666.1	655.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	11.4	12.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	571.1	583.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	475.7	516.4	160.4	162.2	0.0	0.0	0.0	0.0
<b>Татварын бус орлого</b>	<b>1,065.9</b>	<b>942.1</b>	<b>1,224.3</b>	<b>1,197.4</b>	<b>454.1</b>	<b>454.1</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Нийтлэг татварын бус орлого	521.9	552.0	139.0	133.1	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.8	0.4	0.0	0.0	0.0	0.0




Тусламжийн орлого	302.4	213.3	9.9	1.4	454.1	454.1	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	241.5	176.8	1,074.6	1,062.5	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

**Татварын орлого 7,011.2 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 7.4 хувь буюу 481.6 тэрбум төгрөгөөр давж биелжээ.**

Татварын орлогын 25.5 хувийг орлогын албан татвар, 20.2 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.7 хувийг хөрөнгийн албан татвар, 25.2 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.3 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 8.3 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 9.7 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 8. Татварын орлого /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд хөрөнгийн албан татвар болон онцгой албан татварын орлогоос бусад бүх төрлийн татварын орлогууд давж биелсэн байна. Үүнд: орлогын албан татвар 9.0 хувь /146.8 тэрбум.төг/, нийгмийн даатгалын орлого 14.7 хувь /181.8 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 5.0 хувь /0.6 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 6.7 хувь /110.3 тэрбум.төг/, гадаад үйл ажиллагааны орлого 2.2 хувь /12.4 тэрбум.төг/, бусад татвар, төлбөр хураамж 6.7 хувь /42.5 тэрбум.төг/- иар тус тус давж биелсэн байна. Харин онцгой албан татвар 1.6 хувь /10.9 тэрбум.төг/, хөрөнгийн албан татвар 1.5 хувь /1.8 тэрбум.төг/-иар төлөвлөснөөс дутуу төвлөрсөн гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 2.0 хувь /1.6 тэрбум.төг/, дотоодын архи, дарсны онцгой албан татвар 11.9 хувь /18.5 тэрбум.төг/-иар тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ.

**Давж биелсэн нийт татварын орлогын өсөлтийн 37.7 хувийг нийгмийн даатгалын орлого, 30.5 хувийг орлогын албан татвар, 22.9 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 8.8 хувийг бусад татвар, төлбөр хураамжийн орлого, 0.12 хувийг тусгай зориулалтын орлого, 2.6 хувийг гадаад үйл ажиллагааны орлого эзэлсэн бол онцгой албан татвар болон хөрөнгийн албан татвар 0.4-2.3 хувийн бууралттайгаар нөлөөлжээ.**

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2019 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр татварын орлого 1,225.1 тэрбум төгрөг буюу 21.2 хувиар өсөхөд орлогын албан




татвар 371.7 тэрбум (26.3%), нийгмийн даатгалын орлого 273.4 тэрбум (24.0%), хөрөнгийн албан татвар 10.5 тэрбум (10.0%), нэмэгдсэн өртгийн албан татвар 231.9 тэрбум (15.1%), онцгой албан татвар 104.4 тэрбум (18.9%), тусгай зориулалтын орлого 2.5 тэрбум (26.3%), гадаад үйл ажиллагааны орлого 94.9 тэрбум (19.4%), бусад татвар, төлбөр, хураамж 135.9 тэрбум (25.0%) төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

**Татварын орлогын өсөлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад, нийт өсөлтийн 30.3 хувийг орлогын албан татвар, 22.3 хувийг нийгмийн даатгалын орлого, 18.9 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 11.1 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого, 8.5 хувийг онцгой албан татвар, 7.7 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 0.9 хувийг хөрөнгийн албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого тус тус эзэлжээ.**

**Татварын бус орлого 737.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1.0 хувь буюу 7.3 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 47.7 тэрбум төгрөг буюу 6.0 хувиар дутуу төвлөрсөн байна.**

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд гадаад хандив тусламжийн орлого 71.2 тэрбум төгрөгөөр, хувьцааны ноогдол ашиг 15.8 тэрбум, газрын тосны орлого 22.4 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 0.6 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ. Харин торгуулийн орлого 16.0 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 24.7 тэрбум, түрээсийн орлого 0.1 тэрбум, бусад орлого 22.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс илүү төвлөрчээ.

Татварын бус орлогын 92.9 хувийг нийтлэг татварын бус орлого, 7.1 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийт татварын бус орлогод эзлэх нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 29.1 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 23.3 хувийг газрын тосны орлого, 16 хувийг навигацыйн орлого, 7.4 хувийг торгуулийн орлого, 4.1 хувийг хүүгийн орлого, 1.8 хувийг хувьцааны ногдол ашиг, мөн 0.2 хувийг түрээсийн орлого, 11.0 хувийг бусад орлого тус тус эзэлж байна.



Эх сурвалж: Сангийн яам

## 2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 8,601.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 84.5 хувийг ашиглаж, 1,337.3 тэрбум төгрөгийн зардал дутуу зарцуулагдсан байна.

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 816.5 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 548.9 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 16.9 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 67.5 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 789.4 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн зарлага 83.5 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 185.7 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зардал 17.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

### Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл

Хүснэгт 4.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө биелэлт, %	Өөрчлөлт	
	2019.09	2018.09	2019.09	Төлөв/Гүйцэт	Дүн	Хувь
	1	2	3	(3:1)	(2-3)	(2-3)/3
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	8,601.7	6,275.0	7,264.4	84.5	989.4	15.8
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	8,460.7	5,991.9	7,103.8	84.0	1,111.9	18.6
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	6,483.9	5,148.8	5,783.5	89.2	634.7	12.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,191.6	2,228.9	2,699.5	84.6	470.5	21.1
ХҮҮ	649.0	743.5	627.1	96.6	-116.4	-15.7
ТАТААС	247.0	153.5	178.1	72.1	24.7	16.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,396.3	2,022.8	2,278.8	95.1	256.0	12.7
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,976.9	843.2	1,320.3	66.8	477.1	56.6
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	141.0	283.0	160.6	113.9	-122.5	-43.3

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеэс 15.8 хувь буюу 989.4 тэрбум төгрөгөөр өсөхөд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 122.5 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 634.7 тэрбум, хөрөнгийн зардал 477.1 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 116.4 тэрбум төгрөг буюу 15.7 хувиар, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 21.9 тэрбум төгрөгөөр буюу 3.4 хувиар тус тус буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 79.6 хувь буюу 5,783.5 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 46.7 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 39.4 хувийг урсгал шилжүүлэг, 10.8 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.1 хувийг татаас эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 634.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: зээлийн үйлчилгээний төлбөр 116.4 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч бараа, үйлчилгээний зардал 470.5 тэрбум, урсгал шилжүүлэг 256.0 тэрбум, татаас 24.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

### 2.3. Төсвийн тэнцэл

2019 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 484.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 3.5 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарсан байна.

#### Төсвийн тэнцэл

Хүснэгт 5.

/тэрбум.төг/

Үзүүлэлт	Жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар			Төлөв	Гүйцэт	Өөрчлөлт(+/-)	
	2019.09/2018.09		дүн			Хувь	
	2016	2017		2018	2019		
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-2051.70	-737.90	241.7	-1,286.9	484.6	242.9	100.5
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-18.0	-6.1	1.9	-9.4	3.5	-	-

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 52.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ч орон нутгийн төсөв 204.6 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсөв 230.5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 101.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

2019 оны 3 дугаар улирлын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 18.9 хувиар өсч, харин нийт зарлага 15.8 хувиар нэмэгдсэн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг өнгөрсөн оны мөн үеэс 243.0 тэрбум төгрөгөөр өсч, төлөвлөсөн хэмжээнээс 1,771.6 тэрбум төгрөгөөр буурач сайжрахад нөлөөлсөн байна.

2019 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 355.1 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 154.7 тэрбум төгрөг төлж, 667.7 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, мөн 340.2 сая төгрөгийн өмч хувьчлалын орлого төвлөрсөн байна. Шинээр Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд гаргаагүй байна.

## ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

### 3.1. Гадаад худалдааны эргэлт:

**2019 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 9.5 хувь буюу 911.0 сая ам.доллараар нэмэгдэж 10,544.9 сая ам.долларт хүрсэн байна.**

Монгол Улс дэлхийн 146 оронтой гадаад худалдаа хийсэн байна. Экспорт 663.3 сая ам.доллар буюу 12.6 хувиар, импорт 247.8 сая ам.доллар буюу 5.7 хувиар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл сүүлийн дөрвөн жил дараалан ашигтай гарсан байна.

### Гадаад худалдааны үзүүлэлт

Хүснэгт 6.


/сая ам.доллар/

Үзүүлэлт	9 дүгээр сар				Өөрчлөлт	
	2016	2017	2018	2019	Дүн	Хувь
<b>Нийт эргэлтийн бараа</b>	5,780.4	7,707.6	9,633.8	10,544.9	911.0	9.5
-Экспорт	3,332.4	4,582.9	5,282.8	5,946.1	663.3	12.6
-Импорт	2,448.0	3,124.7	4,351.1	4,598.8	247.8	5.7
<b>Тэнцэл</b>	884.4	1,458.2	931.7	1,347.3	415.5	44.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гадаад худалдааны тэнцэл:** 2019 оны эхний 9 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл **1,347.3 сая** ам.долларын ашигтай гарсан. Өмнөх оны мөн үеэс **415.5 сая** ам.доллар буюу **44.6** хувиар өсөхөд экспортын **663.3 сая** ам долларын өсөлт нөлөөлсөн байна.

**Экспорт, импортын жилийн өсөлт:** Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2011.01-2019.09)-аар тооцон үзэв. 2012-2016 онд импорт буурсаар ирсэн бөгөөд 2016 оны сүүлчийн хагас жилээс экспорт болон импортын худалдаа эргэн өсч байна.



**Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл:** Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2019 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 230.0 сая ам.доллараар өсч 1,426.0 сая ам долларын ашигтай гарсан байна.

**Хөрш орнуудтай хийсэн худалдаа:** Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 65.0% буюу 6,825.0 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12.4% буюу 1,312.1 сая ам долларын худалдааг ОХУ-тай хийжээ.

**Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт**

Хүснэгт 7.

/сая ам.доллар/

Улс	Төрөл	3-р улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
		Эзлэх хувь	2017	2018	2019	2019.09/2018.09	
						Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	65.0	4,983.2	6,424.6	6,853.0	428.5	6.7
	Экспорт	89.2	3,974.7	4,920.7	5,305.7	385.0	7.8
	Импорт	33.6	1,008.5	1,503.9	1,547.4	43.5	2.9
	Тэнцэл		2,966.2	3,416.7	3,758.3	341.6	10.0
ОХУ	Нийт эргэлт	12.4	947.8	1,314.3	1,312.1	-2.2	-0.2
	Экспорт	0.9	46.8	63.2	51.5	-11.7	-18.5
	Импорт	27.4	901.0	1,251.1	1,260.6	9.5	0.8
	Тэнцэл		-854.3	-1,187.9	-1,209.1	-21.1	1.8
Бусад	Нийт эргэлт	22.6	1,776.6	1,894.9	2,379.6	484.7	25.6
	Экспорт	9.9	561.4	298.9	588.9	290.0	97.0
	Импорт	38.9	1,215.2	1,596.0	1,790.8	194.7	12.2
	Тэнцэл		-653.7	-1,297.1	-1,201.9	95.2	-7.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт нь БНХАУ-тай хийх экспортын худалдааг 7.8 хувь буюу 385.0 сая ам.доллараар нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Дотоодын гол нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрчимжсэн, нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ өссөн, суудлын болон ачааны автомашины импортын тоо хэмжээ нэмэгдсэн зэргээс шалтгаалан ОХУ-тай хийсэн импортын худалдаа 9.5 сая ам.доллар буюу 0.8 хувиар, БНХАУ-тай хийсэн импорт 43.5 сая ам.доллар буюу 2.9 хувиар тус тус нэмэгдсэн байна. Монгол Улсын гадаад худалдаа нь БНХАУ-тай ашигтай, харин ОХУ-тай алдагдалтай байна.

### 3.2. Экспорт

**Экспортын худалдаа 2019 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр 5,946.1 сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 663.3 сая ам.доллар буюу 12.6 хувиар нэмэгдсэн байна. Үүнд эрдэс бүтээгдэхүүний экспорт 424.1 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.**

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **4,962.6 сая** ам.долларт хүрч, өмнөх оноос **424.1 сая** ам.доллар буюу **9.3** хувиар өссөн бол, эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **938.4 сая** ам.долларт хүрч, өмнөх оноос **239.1 сая** ам.доллар буюу **32.1** хувиар өссөн байна. Нийт экспортын **83.5** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **16.5** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын **98.5** хувь буюу нийт экспортын **82.2** хувийг эзлэж байна.

### Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт

Хүснэгт 8.

№	Төрөл	Хэмжих нэр	2013.09	2014.09	2015.09	2016.09	2017.09	2018.09	2019.09
1	Зэсийн баяжмал	мян.тн	469.2	966.2	1,059.80	1,205.90	1,084.50	1,072.96	1,066.30
		сая ам.дол	679.7	1,684.00	1,715.40	1,273.60	1,155.50	1,487.60	1,421.00
2	Нүүрс	сая.тн	11.4	13.5	10.5	16.2	25.8	27.4	28.6
		сая ам.дол	783.9	633.1	432.9	509.8	1,730.20	2,133.70	2,434.80
3	Төмрийн хүдэр	сая.тн	4.7	4.2	3.4	4.2	4.4	5.3	6.1
		сая ам.дол	478.1	314.3	164.4	167	231.5	240.4	422.3
4	Түүхий газрын тос	сая.баррел	3.5	5.1	5.9	5.9	5.6	4.8	4.8
		сая ам.дол	349	499.9	293.1	236.5	272.3	316.1	316.1
5	Алт	тн	6	5.1	7.6	9.8	9.9	3.43	3.43
		сая ам.дол	245.9	214.1	286.1	399.3	402.8	144.5	144.5
6	Цайрын баяжмал	мян.тн	98	80.4	78.1	97.8	90.7	92.16	100.7
		сая ам.дол	89.3	90	95.6	108.8	133.6	153.5	145.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Чулуун нүүрс** : 2019 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр **2,434.8** сая ам.доллар буюу **28.6** сая тонн чулуун нүүрс экспортлосон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **312.5** сая ам.доллар буюу **1.6** сая тонноор өссөн үзүүлэлт юм. Энэ нь 2018 оны 9-р сард 1 тонн нүүрсний хилийн дундаж үнэ **78.5** ам.доллар байсан бол энэ онд **85.0** ам.доллар болж өссөнтэй холбоотой. Чулуун нүүрсний **98.2** хувийг БНХАУ-руу гаргасан байна.

**Зэсийн баяжмал** : 2019 оны эхний 9 сард **1,066.3** мянган тонн зэсийн баяжмал экспортлосон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал **6.7** мянган тонноор



бага байна. 2018 оны эхний 8 сард зэсийн баяжмалын экспорт үнийн дүнгээр **1,487.6** сая ам.доллар байсан бол тайлант сард **1,421.0** сая ам.доллар болжээ.

**Цайрын баяжмал:** 2019 оны эхний 9 сард **100.7** мянган тонн цайрын баяжмалын **1** тонныг дунджаар **1,441.2** ам.доллараар экспортлосон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн дундаж үнэ **223.8** ам.доллараар буурсан байна. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр **145.1** сая ам.доллар болж, өнгөрсөн оныхоос **8.4** сая ам.доллараар буурчээ.

**Жонш:** 2019 оны эхний 9 сард **155.1** сая ам.долларын **499.9** мянган тонн жонш экспортлосон нь 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **155.3** мянган тонноор, үнийн дүнгээр **39.4** сая ам.доллараар тус тус өссөн байна. Жоншны экспортын дундаж үнэ **310.2** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **25.5** ам.доллараар буурсан байна. Жоншийг БНХАУ, ОХУ, БНСУ руу экспортлосон ба **25.6** хувь ОХУ-д, **74.2** хувь БНХАУ-д тус тус ногдож байна.

**Алт:** 2019 оны эхний 9 сард **7,464.5** кг алт экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **4,032.6** кг-аар их байна. Алтны экспортын дундаж үнэ 2018 оны мөн үед **42,104.9** ам.доллар байсан бол энэ онд **46,121.4** ам.доллар болж **4,016.5** ам.доллараар өссөн байна. Алтны экспорт үнийн дүнгээр **344.3** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **199.8** сая ам.доллараар өсчээ.

### 3.3. Импорт

**2019 оны 3 дугаар улирлын байдлаар импортын хэмжээ 4,598.8 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 247.8 сая ам.доллар буюу 5.7 хувиар өссөн байна.**

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **1,016.9** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **40.9** сая ам.доллар буюу 4.2 хувиар, эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **3,581.9** сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс **206.8** сая ам.доллар буюу **6.1** хувиар тус тус өссөн байна.

Нийт импортын **22.1** хувийг нь эрдсийн бүтээгдэхүүний импорт, **77.9** хувийг нь эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

#### Эрдсийн бүтээгдэхүүний импорт

Хүснэгт 9.

/сая ам.доллар/

Үзүүлэлт	9 дүгээр сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2016	2017	2018	2019	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	502.6	737.6	976.0	1016.9	40.9	4.2	22.1
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	1945.5	2387.1	3375.1	3581.9	206.8	6.1	77.9
<b>Нийт импорт</b>	<b>2448.0</b>	<b>3124.7</b>	<b>4351.1</b>	<b>4598.8</b>	<b>247.7</b>	<b>5.7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2019 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 203 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 49 сая



ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 43 сая ам.доллараар тус тус өссөн бол аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 45 сая ам.доллараар буурснаар нийт импорт 248 сая ам.доллараар өслөө.

### Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

Хүснэгт 10.

/сая ам.доллар/

Бүтээгдэхүүн	3 дугаар улирлын гүйцэтгэл						Өөрчлөлт Сая ам.дол
	2017		2018		2019		
	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	2019/2018
<b>Хэрэглээ</b>	<b>929.0</b>	<b>30.0</b>	<b>1182.0</b>	<b>27.0</b>	<b>1230.0</b>	<b>27.0</b>	<b>48.0</b>
- Түргэн эдэлгээтэй	518.0	17.0	617.0	14.3	621.0	14.0	4.0
- Удаан эдэлгээтэй	411.0	13.0	565.0	12.7	609.0	13.0	44.0
<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>1195.8</b>	<b>38.0</b>	<b>1797.0</b>	<b>41.0</b>	<b>1999.0</b>	<b>43.0</b>	<b>202.0</b>
- Машин, механик тоног төхөрөөмж, эд анги	751.0	24.0	1127.0	26.0	1315.0	29.0	188.0
- Барилгын материал	316.0	10.0	512.0	12.0	512.0	12.0	0.0
- Хөрөнгө оруулалтын бусад бараа	128.8	4.0	158.0	3.0	161.0	4.0	3.0
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>405.0</b>	<b>3.0</b>	<b>553.0</b>	<b>13.0</b>	<b>507.0</b>	<b>11.0</b>	<b>-46.0</b>
- Цахилгаан эрчим хүч	100.0	3.0	105.0	2.0	108.0	2.0	3.0
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>595.0</b>	<b>19.0</b>	<b>815.0</b>	<b>19.0</b>	<b>585.0</b>	<b>19.0</b>	<b>-230.0</b>
- Дизель	326.0	10.0	414.0	10.0	507.0	11.0	93.0
- АИ-92, 95	162.0	5.0	191.0	4.0	211.0	3.0	20.0
- А80 ба бусад	107.0	4.0	210.0	5.0	140.0	3.0	-70.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Импорт нэмэгдэхэд хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 202.0 сая ам.доллар, хэрэглээний бүтээгдэхүүн 48.0 сая ам.доллараар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

## ДӨРӨВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 4.1. Мөнгөний нийлүүлэлт

**Мөнгөний нийлүүлэлт 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 20,414.8 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 2,494.8 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар өссөн байна.**

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бараг мөнгө 2,112.1 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар өссөн нь нөлөөлжээ. Төгрөгийн хадгаламж 1,248.7 тэрбум төгрөг буюу 13.1 хувь, валютын хадгаламж 215.1 тэрбум төгрөг буюу 7.9 хувь, валютын харилцах 648.4 тэрбум төгрөг буюу 28.5 хувиар тус тус өссөн байна.

**Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд**

Хүснэгт 11.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	3 дугаар улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-) 2019.09/2018.09	
	2016	2017	2018	2019	Дүн	Хувь
<b>Мөнгөний нийлүүлэлт (M2)</b>	<b>11,555.9</b>	<b>14,749.7</b>	<b>17,920.2</b>	<b>20,414.8</b>	<b>2,494.6</b>	<b>13.9%</b>
<b>Бараг мөнгө</b>	<b>9,535.3</b>	<b>11,949.3</b>	<b>14,497.1</b>	<b>16,609.2</b>	<b>2,112.1</b>	<b>14.6%</b>
- Төгрөгийн хадгаламж	5,668.1	7,427.7	9,512.8	10,761.5	1,248.7	13.1%
- Валютын хадгаламж	2,439.8	2,601.6	2,709.9	2,925.0	215.1	7.9%
- Валютын харилцах	1,427.4	1,920.0	2,274.4	2,922.8	648.4	28.5%
<b>M1 мөнгө</b>	<b>2,020.5</b>	<b>2,800.4</b>	<b>3,423.1</b>	<b>3,805.5</b>	<b>382.4</b>	<b>11.2%</b>
<b>Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө</b>	<b>795.8</b>	<b>878.9</b>	<b>929.1</b>	<b>889.8</b>	<b>-39.3</b>	<b>-4.2%</b>

Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 18.2 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1.8 их наяд төгрөг буюу 11.1 хувиар нэмэгдсэн байна.

**Зээлийн өрийн үлдэгдэл**

Хүснэгт 12.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	3 дугаар улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-) 2019.09/2018.09	
	2016	2017	2018	2019	Дүн	Хувь
<b>Зээлийн өрийн үлдэгдэл</b>	<b>12,490.9</b>	<b>13,421.4</b>	<b>16,342.4</b>	<b>18,151.1</b>	<b>1,808.7</b>	<b>11.1%</b>
- Хэвийн зээл	10,582.5	11,424.9	13,991.9	15,192.6	1,200.7	8.6%
- Хугацаа хэтэрсэн зээл	789.1	827.0	991.0	985.6	-5.4	-0.5%
- Чанаргүй зээл	1,119.3	1,169.5	1,359.4	1,972.9	613.5	45.1%
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	9.0	8.7	8.3	10.9	2.6	31.3%
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	6.3	6.2	6.1	5.4	-0.7	-11.5%

Эх сурвалж: Монголбанк


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 3 дугаар улирлын эцэст 985.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.4 тэрбум төгрөг буюу 0.5 хувиар буурсан байна. Хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.4 хувь, хэвийн зээлийн 6.5 хувийг тус тус эзэлжээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 3 дугаар улирлын эцэст 1,972.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 613.5 тэрбум төгрөг буюу 45.1 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.9 хувь, хэвийн зээлийн 13.0 хувийг эзэлсэн байна. Зээлийн эргэн төлөлт удааширсан, чанаргүй зээл нэмэгдэж байгаа нь банкны тогтолцооны хувьд ихээхэн эрсдлийг бий болгохоор байна. Нийт чанаргүй зээлийн 82.4 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн

нэгжүүдийн зээл, 16.6 хувийг иргэдийн зээл тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс чанаргүй зээл 45.1 хувиар өссөн бөгөөд энэ өсөлтийн 83.5 хувь буюу 512.3 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж, 14.9 хувь буюу 91.4 тэрбум төгрөгийг иргэдийн зээл эзэлсэн байна.

**Үнэт цаас:** Үнэт цаасны арилжаагаар 2019 оны 3 дугаар улиралд нийт **403.8** сая ширхэг үнэт цаас арилжаалагдаж, **129.8** тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээ 41.4 хувиар буурсан байна. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2019 оны 3 дугаар улирлын байдлаар **26.8** тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 81.6 хувиар буюу **119.0** тэрбум төгрөгөөр буурсан байна. Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2019 оны 3 дугаар улирлын эцэст **19,317.5** болж, өмнөх оны мөн үеэс 717.2 нэгж буюу 3.6 хувиар мөн буурчээ.

**Валютын ханш:** 2019 оны 3 дугаар улиралд Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,669.68 төгрөгт хүрч, өмнөх сараас 0.03 хувиар чангарсан бол оны эхнээс 0.8 хувиар суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 375.28 төгрөг болж өмнөх сараас 0.8 хувиар, оны эхнээс 3.9 хувиар чангарсан байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


**Хэрэглээний үнийн индекс:** Хэрэглээний үнийн улсын индекс 2019 оны 3 дугаар улиралд 9.0 хувь болж өмнөх сараас 0.1 пунктээр, өмнөх оны мөн үеэс 3.3 пунктээр өссөн байна.



Эх сурвалж: Монголбанк

## 4.2. Гадаад валютын албан нөөц

Нийт албан нөөцийн хэмжээ 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 3,985.6 сая ам.долларт хүрээд байна. Гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 1,091.6 сая ам.доллар буюу 37.7 хувиар нэмэгдсэн байна.



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 3,985.6 сая ам.доллар буюу сүүлийн 9 сарын дунджаар тооцсон импортын 7.9 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын хэмжээ өссөн, мөн гадаад валютын албан нөөц өссөн нь импортын сарын хэрэгцээг хангах түвшинг нэмэгдүүлжээ.

### Гадаад валютын албан нөөц ба импорт

Хүснэгт 13.

№	Үзүүлэлт	2014.09	2015.09	2016.09	2017.09	2018.09	2019.09
1	Нийт импорт	4,022.7	2,856.7	2,448.0	3,124.7	4,351.1	4,598.8
2	Гадаад валютын нийт нөөц	1,542.7	1,412.7	1,092.4	1,627.0	2,894.0	3,985.6
3	<b>Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/</b>	<b>3.5</b>	<b>4.5</b>	<b>4.0</b>	<b>4.7</b>	<b>6.0</b>	<b>7.9</b>

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 11.2 тонн болж, өмнөх оны мөн үеэс 3.2 тонноор буурсан байна.



Эх сурвалж: Монгол банк

### 4.3. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2019 оны 3 дугаар улирлын байдлаар урсгал тэнцэл 977.4 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 1392.5 сая ам.долларын илүүдэлтэй, төлбөрийн тэнцэл 264.3 сая ам.долларын ашигтай гарч, алдагдал өнгөрсөн оныхоос 739.6 сая ам.доллараар буурч, төлбөрийн тэнцэл сайжирсан байна.

2019 оны 3 дугаар улирлын байдлаар урсгал тэнцлийн алдагдал 977.4 сая ам.доллар, үүний дотор цэвэр урсгал шилжүүлэг 195.4 сая ам.доллар гарсан бол харин бараа ба үйлчилгээ 28.9 сая ам.доллар, цэвэр орлого 1,143.9 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал тэнцлийн алдагдал 409.0 сая ам.доллараар буурсан байна. Урсгал тэнцлийн алдагдал буурахад бараа, үйлчилгээний худалдааны тэнцлийн алдагдал 736.6 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

2019 оны 3 дугаар улирлын байдлаар хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 1392.5 сая ам.долларын илүүдэлтэй гарсан нь өмнөх оны мөн үеэс 262.6 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Төлбөрийн тэнцэл 264.3 сая ам.долларын ашигтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 739.5 сая ам.доллараар нэмэгдэн алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл ашигтай гарчээ.

#### Төлбөрийн тэнцэл, 2017.09 - 2019.09

Хүснэгт 14.

Үзүүлэлт	Гүйцэтгэл			3 дугаар улирлын өөрчлөлт (+/-)	
	2017.09	2018.09	2019.09	2018/2017	2019/2018
<b>I. Урсгал Тэнцэл</b>	<b>-565.6</b>	<b>-1386.4</b>	<b>-977.4</b>	<b>-820.8</b>	<b>409.0</b>
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	396.0	-765.5	-28.9	-1161.5	736.6
В. Орлого	-1089.3	-874.0	-1143.9	215.3	-269.9
С. Урсгал шилжүүлэг (цэвэр)	127.7	253.1	195.4	125.4	-57.7
<b>II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл</b>	<b>973.5</b>	<b>1129.9</b>	<b>1392.5</b>	<b>156.4</b>	<b>262.6</b>
А. Хөрөнгийн данс	56.7	62.7	70.3	6.0	7.6
В. Санхүүгийн данс	916.8	1067.2	1322.2	150.4	255.0
<b>III. Алдаа болон орхигдуулга</b>	<b>-205.9</b>	<b>-218.8</b>	<b>-150.7</b>	<b>-12.9</b>	<b>68.1</b>
<b>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</b>	<b>201.9</b>	<b>-475.3</b>	<b>264.3</b>	<b>-677.2</b>	<b>739.6</b>

Эх сурвалж: Монгол банк

**ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ****5.1. Хүн ам, ажил эрхлэлт**

Ажиллах хүчний судалгааны 2019 оны 3 дугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын 1.3 сая нь ажиллах хүч байгаа бөгөөд ажиллах хүчний оролцооны түвшин 60.1 хувь байна. Ажиллах хүчний оролцооны түвшинг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүд 67.4 хувь, эмэгтэйчүүд 53.5 хувь байна. Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.2 хувь байна. Хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүд 60.1 хувь, эмэгтэйчүүд 48.8 хувь байна.

Ажиллах хүчний 1.2 (90.1%) сая нь ажиллагчид, тэдгээрийн 10.9 (0.9%) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна. Харин улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын 850.9 (39.9%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам, тэдгээрийн 51.3 (6.0%) мянга нь цалин хөлс, орлого олох ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажилгүй хүний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүчинд багтаж байна.

**5.2. Ажилгүйдэл**

2019 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 9.9 хувьтай болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.0 пунктээр өссөн ч, өмнөх улирлаас 0.2 пунктээр буурсан байна. Харин 2018 оны жилийн эцэстэй харьцуулахад ажилгүйдлийн түвшин 3.3 пунктээр өссөн байна. Ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо буурч, макро эдийн засагт сэргэлт гарч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, тэдгээрийн бизнесийн идэвхжил сайжирч байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь ажлын байр шинээр бий болох, ажилгүйдлийн түвшин буурах нөхцлийг бүрдүүлэх боломжтой юм.


**ДҮГНЭЛТ****1. Эдийн засагт гарч буй нааштай өөрчлөлтүүд**

- **Эдийн засагт бодит өсөлт гарч байна.** 2011 онд 17.5 хувь байсан эдийн засгийн өсөлт тасралтгүй буурч 2016 оны эхний 3 дугаар улиралд 1.6 хувьд хүртэл унасан. Харин 2016 оны 3 дугаар улирлаас хойш аажмаар өссөөр 2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 6.3 хувьтай боллоо. Энэхүү өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтийн нөлөөгөөр экспортын орлого нэмэгдсэн, үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт өсөлт гарч эхэлсэнтэй холбоотой байна.
- **Төсвийн орлого нэмэгдэж байна.** Нэгдсэн төсвийн орлого 2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 7,749.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1,232.4 тэрбум, төлөвлөгөөнөөс 434.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Хөрөнгийн албан татвар болон онцгой албан татварын орлогоос бусад бүх орлогууд төлөвлөснөөс давж биелсэн байна.
- **Төсвийн орлогын өсөлт, зарлагын хэмнэлтийн нөлөөллөөр нэгдсэн төсвийн тэнцэл ашигтай гарлаа.** 2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар төсвийн тэнцлийн ДНБ-нд эзлэх хувь 3.5 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 1.6

пунктээр өсч, алдагдалтай төлөвлөсөн 2019 оны төлөвлөсөн дүнгээс 12.9 пунктээр буурч, төсвийн тэнцэл сайжирч байна.

- **Гадаад худалдааны үзүүлэлтүүд сайжирч, экспорт болон импортын худалдаа нэмэгдэж, гадаад худалдааны ашиг өсч байна.** Экспорт 2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 5,946.1 сая ам.доллар болж 663.3 сая ам.доллар буюу 12.6 хувь, мөн импорт 4,598.8 сая ам.долларт хүрч 247.8 сая ам.доллар буюу 5.7 хувиар өслөө. Импортын өсөлтөөс илүүгээр экспорт нэмэгдсний нөлөөллөөр гадаад худалдааны тэнцлийн ашиг өмнөх оны мөн үеэс 415.5 сая ам.доллар буюу 44.6 хувиар өсч 1,347.3 сая ам.доллар боллоо. Экспортын өсөлтөд эрдсийн бүтээгдэхүүний экспорт, харин импортод уул уурхайн үйлдвэрлэл, түүнийг дагасан үйлчилгээний өсөлт, ялангуяа машин, механик, тоног төхөөрөмжийн эд анги, бензин, дизель түлшний импорт нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
- **Мөнгөний нийлүүлэлт өслөө.** Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 81.4 хувийг төгрөгийн хадгаламж, валютын хадгаламж, валютын харилцах, үлдэх 18.6 хувийг банкны харилцах, гүйлгээнд гарсан бэлэн мөнгөний өсөлт нөлөөлжээ.
- **Гадаад валютын албан нөөц тогтвортой өсч, импортын хэрэгцээг хангах түвшин нэмэгдэж байна.** Гадаад валютын албан нөөц өмнөх жилүүдэд тасралтгүй буурч 2016 оны 9 сард 1,092.4 сая ам.долларт хүрсэн хэдий ч 2017 оны эхнээс эргэн өсч 2019 оны 9 сард 3,985.6 сая ам.доллар болсон байна. Энэ нь сүүлийн 9 сарын дунджаар тооцсон импортын 7.9 сарын хэрэгцээг хангах түвшинд болж өмнөх оны мөн үеэс 1.9 пунктээр өссөн үзүүлэлт юм.
- **Төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа.** Төлбөрийн тэнцэл 2019 оны 9 сард 264.3 сая ам.долларын ашигтай гарлаа. Үүнд гадаад худалдааны тэнцлийн ашиг, гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтын орлогын өсөлт голлон нөлөөлжээ.
- **Зээлийн үйлчилгээний төлбөр буурсан байна.** Нэгдсэн төсвийн зээлийн үйлчилгээний төлбөр 2019 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр 627.1 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 8.1 хувь, нийт зарлагын мөн 8.6 хувийг эзэлж байна. 2013 оны мөн үетэй харьцуулахад зээлийн үйлчилгээний төлбөр 2019 оны 3 дугаар улиралд ойролцоогоор 4.5 дахин өссөн байна. Харин 2017 оны мөн үетэй харьцуулахад зээлийн үйлчилгээний төлбөр 2019 оны 3 дугаар улиралд 150.0 тэрбум төгрөгөөр буюу 19.3 хувиар буурсан байна. Цаашид зээлийн үйлчилгээний төлбөрийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Түүнчлэн зээлийн үйлчилгээний төлбөр тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 68.9 тэрбум төгрөгөөр бага байгаа нь улсын төсөвт нөлөөлөх хүүгийн зардал буурах төлөвийг харуулж байна.

Зээлийн үйлчилгээний төлбөр, тэрбум төгрөгөөр





## **2. Нийгэм, эдийн засагт тулгамдаж буй зарим асуудал**

- **Чанаргүй зээл өссөн байна.** 2019 оны 9 сарын байдлаар чанаргүй зээл 613.5 тэрбум төгрөгөөр буюу 28.5 хувиар өсч 1,972.9 тэрбум төгрөгт хүрлээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.9 хувийг эзэллээ. Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдлийг бууруулахгүйгээс банк, санхүүгийн тогтолцоонд томоохон эрсдлүүд үүснэ.
- **Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааны идэвх багассан.** Үнэт цаасны арилжаа хумигдаж, гүйлгээ 129.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 41.4 хувиар буурчээ.
- **Инфляци нэмэгдсээр байна.** 2019 оны 3 дугаар улиралд инфляцийн түвшин 9.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.3 пункт, 2018 оны жилийн эцсээс 0.9 пунктээр тус тус өссөн байна. Энэ нь Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл болон Монгол Улсын 2019 оны төсвийн төсөлд тусгасан инфляцийг 8 хувьд барих бодлогоос даруй 1.0 пунктээр өссөн үзүүлэлт юм. Инфляци нам түвшинд тогтвортой байх нь эдийн засагт идэвхжлийг бий болгож, үйлдвэрлэлийг дэмждэг тул бууруулах арга хэмжээг авах шаардлагатай.
- **Ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр байна.** 2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 9.9 хувьтай болж, өмнөх оны мөн үеэс 3.0 пунктээр, 2018 оны жилийн эцсийн дүнгээс 3.3 пунктээр тус тус өссөнийг анхаарч бууруулах шаардлага байна.
- **Хөрш орны эдийн засгаас хамааралтай, түүхий эдэд суурилсан экспортын бүтэцтэй хэвээр байна.** Нийт экспортын 90 гаруй хувийг баяжмал, хүдэр, түүхий эд зонхилж байна. Нийт гадаад худалдааны эргэлтэд хөрш орнууд дийлэнх хувийг эзэлж байна. Нэмүү өртөг шингэсэн томоохон үйлдвэрүүдийг шинээр барих, мега төсөл, хөтөлбөрүүдийг эдийн засгийн эргэлтэд шуурхай, хугацаа алдалгүй оруулах, ЖДҮ эрхлэгчдийг төсөв, санхүүгийн бодлогоор дэмжих замаар шинээр ажлын байр нэмэгдүүлэх, импортыг орлуулах, экспортыг дэмжсэн үйлдвэрлэлийг өсгөх, экспортын бүтцэд өөрчлөлт гаргах нь зүйтэй байна.

---oOo---

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА